



ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2021 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/10

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4 дэх заалт, Засгийн газрын “Журам батлах тухай” 2018 оны 382 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт “Төрийн албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 2-т, Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны “Эмгэг судлалын үндэсний төвийн дүрэм, бүтцийг шинэчлэн батлах тухай” А/294 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан дүрмийн 4.3, “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 3.1-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эмгэг судлалын үндэсний төвийн эмч, лабораторийн техникч, бусад ажилтанд ур чадварын нэмэгдэл олгох шинэчилсэн журмыг нэгдүгээр, ур чадварын үнэлгээний комиссын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмыг батлагдсан өдрөөс эхлэн мөрдөн ажиллахыг албадын дарга, тасгийн эрхлэгч нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлтийн алба /О.Дуламсүрэн/-д үүрэг болгосугай.
4. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Эмгэг судлалын үндэсний төвийн захирлын 2020 оны А/31 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ

J. Уяанга


Г.УЯАНГА



53001717

E:\2021\А тушаал.docx

Эмгэг судлалын үндэсний төвийн
Захирлын 2021 оны 02 дугаар
сарын 01 -ны өдрийн 1/10 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



**ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЭМЧ,
ЛАБОРАТОРИЙН ТЕХНИКЧ, БУСАД АЖИЛТАНД УР
ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу ажил, албан тушаал эрхэлж байх хугацаанд нь Эмгэг судлалын үндэсний төвийн эмч, лабораторийн техникч, ажилтан нарын ажил гүйцэтгэх чадвар, ажлын арга барил, идэвхи санаачилгыг нь дэмжих, үр дүнтэй ажиллуулах зорилгоор Засгийн газар болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ур чадварын шалгуур үзүүлэлтийг тооцох журмыг үндэслэн, тэдэнд энэхүү журмын дагуу ур чадварыг үнэлэх, тооцох, нэмэгдэл олгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

**Хоёр. Ажилтны ур чадварыг тооцохтой
холбоотой үнэлэх үйл явц**

2.1. Төвийн албадын дарга, лаборатори, тасгийн эрхлэгч нар ажилтны ур чадварыг тооцохдоо дараах арга хэмжээ авсан байна. Үүнд:

2.1.1. Ажилтан бүр ур чадварын үнэлгээний дэвтэртэй байх бөгөөд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа бүрийг тасгийн эрхлэгчээр баталгаажуулан, хагас жил бүр харьяалах албаны даргад хянуулах;

2.1.2. Албадын дарга нар тасаг хамт олны хурлыг зохион байгуулан, үнэлгээ хийсэн байх;

2.1.3. Чанарын алба төвийн ажилтнуудын ажлын үнэлгээг хагас жилд нэгтгэн Удирдлагын зөвлөлд танилцуулж, хэлэлцүүлэх;

2.2. Төвийн удирдлагын зөвлөлийн хурлаар ажилтны ур чадварын нэмэгдэл олгох эсэх асуудлыг хэлэлцүүлэхэд дараах баримт бичиг, материалыг бүрдүүлнэ. Үүнд:

2.2.1. Ажилтны ур чадварыг үнэлсэн баримт бичиг (ур чадварын дэвтэр);

2.2.2. Ажилтны тухайн алба, лаборатори, тасаг хамт олны хурлын тэмдэглэл;

2.2.3. Ажилтны шинээр санаачлан хийж гүйцэтгэсэн ажил, бүтээл, түүний үр дүнгийн талаарх тайлан, үр ашгийн тооцоо, мэргэжлийн салбар зөвлөл болон эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн судалгаа;

Гурав. Ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт

3.1. Дараах шаардлагыг хангасан албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгоно.

3.1.1. Мэргэжлийн хувьд гоц авъяас чадвартай, ажил үйлчилгээг бусдаас илүү чадварлаг, дэвшилтэт арга барилаар хийж дадлагажсан байх;

3.1.2. Ажил үйлчилгээг улсын стандарт, чанарын өндөр түвшинд хийж хэвшсэн байх;

3.1.3. Эмчилгээ, үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажилд шинэ арга технологи нэвтрүүлж өндөр үр дүнд хүрсэн байх;

3.1.4. Мэргэжлийн ур чадвар, ажлын амжилт, бүтээлийг нь мэргэжлийн байгууллага, хүмүүс, үйлчлүүлэгчид үнэлсэн байх;

3.1.5. Ажил мэргэжлээрээ байгууллага хамт олон дотроо удаа дараа шалгарсан байх;

3.1.6. Мэргэжлийн ур чадвараа байнга өндөр түвшинд байлгаж, түүнийгээ бусдад зааж сургах талаар санаачлага гаргаж ажилладаг байх.

3.2. Энэхүү журмын 3.1.2, 3.1.4, 3.1.5, 3.1.6-д дурдсан тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан бол ажилтанг ур чадвартайд тооцно.

Дөрөв. Ажилтанд ур чадварын нэмэгдэл олгох

4.1. Төвийн эмч, лабораторийн техникч, бусад ажилтныг албан тушаал, ажил эрхэлж байх хугацаанд нь энэхүү журмын 3.1, 3.2-т заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаж, ур чадварыг тооцож, үнэлгээ хийж, удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, төвийн захирал Засгийн газраас тогтоосон хувь хэмжээгээр албан тушаалын сарын цалингийн 10-25 хувиар тооцож, сар бүр олгох асуудлыг шийдвэрлэнэ.

4.2. Хэрэв төвийн ажилтан улсын хэмжээнд болон өөрийн салбартаа энэхүү журмын 3.1.1, 3.1.3-т дурдсан шалгуур үзүүлэлтийг хангасан бол төвийн захирлын тушаалаар тухайн ажилтанд ур чадварын нэмэгдлийг шууд олгоно.

4.3. Оны шилдэг ажилчдыг бүтэн жилээр ур чадварын нэмэгдлийг олгоно.

4.4. Ур чадварын үнэлгээг ажилтны сүүлийн 6 сарын хугацаанд хийж гүйцэтгэсэн ажил, идэвх санаачлагатай ажилласан байдлыг харгалзан олгоно.

Тав. Ур чадварын нэмэгдэл олгохгүй байх нөхцөл, хамаарахгүй тохиолдол

5.1. Төвийн ажилтанд дараах нөхцөл, тохиолдолд ур чадварын нэмэгдэл олгохгүй, хамаарахгүй. Үүнд:

5.1.1 Туршилт болон дагалдан ажиллуулах хугацаанд ажиллаж байгаа ажилтанд;

5.1.2 Урамшуулал авах хугацаандаа цалингүй болон үндсэн цалинтай чөлөө авсан бол чөлөөний хугацаанд олгогдохгүй;

5.1.3 Урамшуулал авах хугацаандаа цалингүй болон үндсэн цалинтай чөлөө авсан бол чөлөөний хугацаанд олгогдохгүй;

5.1.4 Ажилтан гэмт хэрэг, зөрчилд холбогдож хууль хяналтын байгууллагаар тогтоогдсон бол;

5.1.5 Сахилгын шийтгэлтэй бол;

5.1.6 Энэхүү журмын 3.1-т заасан шаардлагыг хангаагүй бол;

Эмгэг судлалын үндэсний төвийн
Захирлын 2021 оны 02 дугаар
сарын 01 -ны өдрийн 410 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

УХА0300 0123267

УР ЧАДВАРЫН ТҮВШИН ТОГТООХ КОМИСС
БАЙГУУЛАХ ТУХАЙ

Комиссын дарга

Нарийн бичгийн дарга

Гишүүд

Төвийн захирал

Чанарын албаны дарга

Эмгэг судлалын түслэмж үйлчилгээний
албаны дарга

Лавлагаа лабораторийн эрхлэгч

Үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл

Хүний нөөцийн менежер

